



2023

III УЛИРЛЫН ТАЙЛАН

2023 оны 10 сарын 23

АГУУЛГА

- Гүйцэтгэх захирлын илгээлт

- Төлөөлөн удирдах зөвлөл

- Гүйцэтгэх удирдлага

- Үйл ажиллагааны тайлан

 - Банкны кластер

 - Даатгалын кластер

 - Хөрөнгө оруулалтын банкны кластер

- Нэгтгэсэн тоон үзүүлэлт

- Ард Апп

- Хөрөнгө оруулалтын багц

- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц - AARD

- Санхүүгийн тайлан

 - Орлогын тайлан

 - Санхүүгийн байдлын тайлан

 - Үнэлгээ

- Хувьцааны арилжаа





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Дэлхий дахиныг донсолгосон цар тахал, Орос Украины дайн зэрэг гадаад дотоод улс төрийн болон геополитикийн хүчин зүйлсээс үүдэлтэйгээр нийлүүлэлтийн гинжин хэлхээ тасрах, инфляц өсөх, гадаад валютын ханш чангарах гэх мэт эдийн засгийн олон сорилтуудыг Монгол Улс даван гарч, сэргэлтийн замдаа орж байгааг олон үзүүлэлт харуулж эхлээд байна. Энэхүү сэргэлтийг бизнестээ зөвөөр шингээж, өргөжин тэлэхдээ ашиглах нь манай компанийн цаашдын хөгжилд ихээхэн чухал бөгөөд эдийн засгийн дараах гол үйл явдлууд бидний бизнесийн орчныг тодорхойлж байна.

Эдийн засгийн өсөлт ба экспорт:

Эдийн засаг оны эхний хагаст нүүрсний экспортын өсөлт, тээвэр, үйлчилгээний салбарын хурдцын нөлөөгөөр 6.4 хувийн өсөлт үзүүлээд байна. Уул уурхайн салбарын экспорт өсөлттэй байдлаа хадгалж чадвал оны эцэст 5-6 хувийн өсөлттэй байх төлөвтэй байгаа бөгөөд уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтийн гол чиглүүлэгч хэвээр байна.

Инфляцыг барих:

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт үзүүлэхэд инфляцыг барих нь чухал байдаг тул Төв банк одоогийн бодлогын хүүг 13 хувиас бууруулахгүй байх мөнгөний хумих бодлогоо үргэлжлүүлэн инфляцыг зорилтот 6 хувьд (4-8 хувийн хооронд) барихыг хичээж байна. Энэ бодлогын үр дүнд инфляцын түвшин буурсаар 8 сард 10 хувьд хүрээд байна.

Төлбөрийн тэнцэл:

Экспортын эрчийг хадгалж, гадаад валютын цэвэр урсгал үүссэн нь 8 сард гадаад валютын нөөц 3.9 тэрбум долларт хүрэхэд нөлөөлсөн бөгөөд энэ нь сүүлийн 20 сарын хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Энэ нь ойрын ирээдүйд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш тогтворжино гэсэн итгэлийг дагуулж байна.

Хүндрэл, бэрхшээл:

Дээр дурдсан эерэг үзүүлэлтүүд байгаа хэдий ч нийгэм, эдийн засаг, улс төрийн орчин дахь гадаад болон дотоод тодорхойгүй байдлаас шалтгаалсан эрсдэлүүд байсаар байна. Төсөв, мөнгөний бодлого уялдаатай байх, ялангуяа ирэх оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн, нийлүүлэлтийн гинжин хэлхээг тогтвортой явуулах, ялангуяа хүнсний хэрэгцээгээ дотооддоо бүрэн хангах нь маш чухал юм.

Цаашдын бодлого:

Монгол улс эдийн засгийн өндөр өсөлттэй байх дунд хугацааны зорилтдоо хүрэхийн тулд 2024 онд инфляцыг тогтворжуулахад гол анхаарлаа хандуулна гэж харж байна. Үүнд дотоодын зах зээлд гадаадын банкны нэгжийг бий болгох, ногоон зээлийн хэмжилтийн системийг хөгжүүлэх зэргээр Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, цахим системээр дамжуулан хил дамнасан худалдааг идэвхжүүлэх зэрэг алхмууд чухал ач холбогдолтой.

Ерөнхийдөө Монгол Улсын эдийн засаг эерэг хандлагатай байгаа ч болзошгүй сорилтыг даван туулах, энэ өсөлтийг тогтвортой хадгалах идэвхтэй бодлого хэрэгтэй байна.

III улиралд Нэгдлийн хэмжээнд хөрөнгө, өрийн удирдлага, байгууллагын бүтцийн оновчлолд анхаарч, дараагийн гурван жилийн хугацааны OGSM (objective, goals, strategies, and measures) -ээ тодорхойлсон. Шинэ OGSM-ийг IV улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт 10 сарын 26-нд болсон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар танилцуулж, батлуулсан бөгөөд 2024-2026 он хүртэлх шинэ бизнес төлөвлөгөөг 12 дугаар сард товлож буй оны сүүлчийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, ирэх оны төсөвтэй хамт батлуулахаар зорьж байна.

Нэгдлийн хэмжээнд холбогдох баг, бүрэлдэхүүн бүтцийн оновчлолтой холбоотой гэрээ, хэлцлүүд дээр дараах байдлаар ажиллаж байна:

Санхүүгийн бус компаниудыг Ард Венчурс компани руу шилжүүлж, санхүүгийн компаниудын шууд өмчлөлийг бий болгох зорилгоор Нэгдлийн компанийн хөрөнгө оруулалтын багцад бүтцийн өөрчлөлт хийснээр үндсэн бизнестээ төвлөрөх боломжтой болно. Үүний хүрээнд үндсэн санхүүгийн компаниудаа тус тусын салбарт нь өргөжүүлж, хоорондын сонирхлын зөрчлийг багасгах юм.

Ардын Тэтгэврийн Данс компанийн бүтцийн өөрчлөлт үргэлжлэн хийгдэж байна. Энэ хэлцлийн хүрээнд Ард Санхүүгийн Нэгдэл нь Ардын Тэтгэврийн Данс, Монгол Шуудан, ТэнГэрЛиг Медиа Нэгдэл зэрэг хөрөнгийг Хөрөнгийн биржид бүртгэлтэй Өндөрхаан ХК-руу шилжүүлнэ.

Энэ жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан хувьцааг эргүүлэн худалдаж авах хөтөлбөрийг нэмэлт зардал, хураамжаас зайлсхийхийн тулд түр зогсоосон. Энэхүү шийдвэр нь хувьцааны үнэ бага байхад Ард Санхүүгийн Нэгдлийн 10 хувийг охин компаниудаас нь эргүүлэн худалдаж авах, татварын нөлөөллийг багатайгаар стратегийн хөрөнгө оруулагчдад илүү өндөр үнээр худалдах зорилготойгоор батлагдаж байсан ч зах зээлийн орчин төсөөлсөн шиг ажиллах боломжыг олгосонгүй.

Үүний зэрэгцээ, Нэгдлийн бүрэлдэхүүнд багтаж буй компаниуд өнгөрсөн хугацаанд борлуулалт, өсөлт дээрээ төвлөрөн ажиллаж, маш сайн үр дүн харуулсаар байна:

Ард Кредитын зээлийн багц хурдацтайгаар өсч 50 тэрбум төгрөгийн босгыг давсан бөгөөд энэ нь он гарснаас хойш 10 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Компани хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ABS) гаргахын тулд барьцаат зээлийн багц бүрдүүлэхэд голчлон анхаарч автомашин барьцаалсан зээлд 6.7 тэрбум төгрөгийг гаргасан байна. Мөн нэмэлт хувьцаа гаргах (FPO) хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос сар орчмын өмнө баталж, зөвшөөрөл олгосон нь компанийн хөгжлийн хувьд томоохон түүхэн үйл явдал боллоо. Тус зөвшөөрлийн дагуу Ард Кредит нэмэлтээр 30 хувьтайгаа тэнцэх хэмжээний хувьцаа гаргах бөгөөд 8.9 тэрбум төгрөгийн хөрөнгө босгосноор эздийн өмчийг энэ хэмжээгээр ихэсгэж, 36 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилт татах орон зайтай болох юм. FPO болон ABS-ийн тусламжтайгаар Ард Кредит нь ойрын хугацаанд 100 тэрбум төгрөгийн зээлийн багцад хүрэх боломжтой юм.

Ард Актив ХЗХ энэ онд нийт хөрөнгөө 8.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 40 тэрбум төгрөгт хүргэж чадлаа. Хоршоо нь гишүүдийн тоогоо тогтмол нэмэгдүүлсээр одоогийн байдлаар 3,500 гаруй гишүүдтэй болсон байна. Үүнээс гадна, Ард Апп хэрэглэгчдийг хялбар замаар хоршооны гишүүд болгож, гишүүдийн тоогоо хурдацтайгаар нэмэгдүүлэхийг зорьж ажиллаж байна. Компанийн зөв засаглал, үр ашигтай бүтэцтэй ажиллаж ирсний хүчинд сүүлийн хэдэн жилд тогтвортой ашиг олохын зэрэгцээ зээлийн багцын чанараа маш сайн байлгаж, хугацаа хэтэрсэн зээлийг 1 хувиас бага түвшинд барьж байна.

Ард Лизинг үйл ажиллагааг зах зээлийн уналттай нөхцөл байдлаас шалтгаалан жилийн туршид идэвхгүй байдлаар удирдсан ч, сүүлийн үед лизингийн үйл ажиллагааг сэргээж эхэлсэн бөгөөд оны эцэс гэхэд Өсдөг Машин хөтөлбөрт 1,000-аас доошгүй автомашиныг хамруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Даатгалын салбар байгалийн гамшиг, өндөр инфляцын улмаас ганхаж, нөхөн төлбөрийн хэмжээ салбарын хэмжээнд огцом өссөн хэдий ч Ард Даатгал ХК энэ жил маш өндөр амжилт үзүүллээ. Тус компани III улирлын байдлаар 22.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь бүх цаг үеийн хамгийн өндөр борлуулалт болсон төдийгүй оны эцэст 25 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлэх төлөвтэй байна. Удирдлагын баг нь ТУЗ-ийн хамтаар IPO хийсний дараах 5 жилийн бизнес төлөвлөгөөндөө дүгнэлт хийж, зах зээлийн байршил, борлуулалт, өсөлт болон инноваци, цахимжилтийг хослуулан 3 жилийн шинэ бизнес төлөвлөгөөгөө амжилттай хэлэлцэв.

Ардын Тэтгэврийн Данс нь байгууллагын борлуулалтад илүү анхаарал хандуулснаар сар бүр татдаг тэтгэврийн хуримтлалаа ихээр нэмэгдүүлж ажиллав. Зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн хөрөнгө оруулалтын багцын үнэлгээ унасан ч компани хөрөнгө оруулалтын багцаа оновчтой болгох, тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, хувьцааны хөрөнгө оруулалтаа багасгаж ажиллав. Мөн тэд УИХ-аар хэлэлцэх Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөлд оролцогч талуудтай хамтран идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд уг хууль зөв батлагдах нь компанийн ирээдүйд маш чухлаар нөлөөлөх юм.

Ард Секюритиз ҮЦК-ийн хувьд бонд босгох, дахин санхүүжүүлэх, тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнүүд болон хувьцаа, тэр дундаа СЗХ-ноос IPO гаргах зөвшөөрлөө дөнгөж аваад буй МОСТ Финтек компани, Ард Кредитын FPO зэрэг хөрөнгийн зах зээлтэй холбоотой бүхий л төслүүдэд Нэгдлийн хүрээнд тэргүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байна. Мөн компани энэ улиралд үндсэн системээ улам сайжруулж, хэрэглэгчдэдээ хялбар цахим шийдлээр арилжаанд оролцох, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгосон юм.

Ард Менежмент нь Үндэсний Хувьчлалын Сан болон Хөрөнгө Оруулагч Сангаа амжилттай удирдаж, төлөвлөсөн гүйцэтгэлдээ хүрч ажиллаа. Хэдийгээр зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн багцад буй хөрөнгийн өсөлт болон нэгж эрхийн борлуулалт төлөвлөснөөс бага байгаа ч анх байгуулагдсан цагаас хойшхи багцын өсөлт өндөр хэвээр байна. Компани сангийн үйл ажиллагаа, нэгж эрхийн талаар мэдээлэл олгох ажлыг олон нийтэд тасралтгүй хийж байна. Мөн компани тэматик сангуудыг (thematic funds) байгуулахаар ажиллаж буй бөгөөд тус сангууд байгуулагдсанаар жижиг хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийх хамгийн хялбар боломжийг олгох юм.

Ард Пропертиз нь Блю Скай Тауэрын 9 давхрыг токенжуулах төслийг туршиж, үл хөдлөхийн салбарт хувьсал хийхээр зорьж ажиллаж байна. Компани тус үл хөдлөх хөрөнгийг худалдан авах санхүүжилтээ амжилттайгаар шийдвэрлэж, түрээслүүлэхэд бэлэн болгож засварлаж, бүхэлд нь 5 жилийн хугацаагаар түрээслүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Улмаар 7 сараас эхлэн сар бүр түрээсийн орлогыг токен эзэмшигчдэдээ хуваарилж эхлээд байна.

Багцдаа байгаа компаниудаа уламжлалт арга барилаар өргөжүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ бид дижитал экосистемээ онцгойлон Ажайл (Agile) аргачлалаар хөгжүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, Ард Апп хөгжүүлэлтийн төсөлд энэ аргачлалыг ашигласнаар богино хугацаанд сайн үр дүн үзүүлж эхлээд байна. Тус аргачлалын дагуу өнгөрсөн улиралд МОСТ Финтек болон ГрэйпСити Монгол компаниудтай хамтарсан манай баг Ард Аппын тогтмол сайжруулалт хийж, алдааг засч шинэ хувилбарыг бүрэн нэвтрүүлэх дээр төвлөрөн ажилласан ба 10 сард Ард Аппын V4 хувилбар унтарч, V5-руу амжилттайгаар бүрэн шилжих төлөвтэй байна. Манай технологийн баг хэрэглэгчийн туршлага, интерфейс дээр голчлон анхаарч, санхүүгийн үйлчилгээ авах алхмуудыг хамгийн боломжит түвшинд хүртэл багасгаж, бусад платформ, системүүдтэй интеграци хийх ажлыг эрчимтэй хийж байна. Үүний зэрэгцээ бид СКОПА (нийлүүлэлтийн гинжин хэлхээний платформ) болон АрдСтор (шинэчлэгдсэн цахим худалдааны платформ) платформуудаар дамжуулан олон байгуулагыг өөрсдийн төлбөрийн болон урамшууллын системдээ нэгтгэсээр байна. Үүний үр дүнд, манай харилцагчид Ард Аппаа өдөр тутамдаа төлбөр тооцоо хийхдээ ашиглаж, урамшууллалд нь АрдКойн цуглуулж, санхүүгийн үйлчилгээг амар хялбар байдлаар нэг дороос авах боломжтой болж байгаа юм. Бид харилцагчиддаа зориулсан автоматаар тэтгэврийн хуримтлал, хөрөнгө оруулалт хийх боломжуудыг олгохын хамт хувийн санхүүгээ удирдахад туслах замаар ирэх оны 7 сар гэхэд Ард Аппыг өдөр тутамдаа тогтмол ашигладаг 100,000 идэвхтэй хэрэглэгчтэй болгохоор зорин ажиллаж байна.

Төгсгөлд нь хэлэхэд, хувьцаа эзэмшигч та бүгдийн төлөөлөл болсон ТУЗ, болон компанийн удирдлагын зүгээс намайг Гүйцэтгэх Захирлын албан тушаалд томилохыг дэмжсэнд гүнээ талархахын сацуу маш өндөр үүрэг хариуцлагыг, итгэлийн хамт хүлээлгэж байгааг би ихэд ухамсарлаж буйгаа илэрхийлэх нь зүйтэй гэж үзлээ. Компанийн болон миний хувьд хийгдэж буй энэ шилжилтийн цаг үед үнэлж баршгүй зөвлөгөө, дэмжлэгээр хангаж буй өмнөх захиралдаа гүнээ талархаж байгаагаа мөн илэрхийлье. Миний бие компанийн бат бөх тавигдсан суурийг улам бэхжүүлж, хамт олныхоо хамтаар шинэ амжилтын оргил өөд тэмүүлж ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Батбилэгийн Золбоо

Гүйцэтгэх Захирлын Үүргийг Түр Орлон Гүйцэтгэгч,
Ард Санхүүгийн Нэгдэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн Дарга



Чулууны **Ганхуяг**
ТУЗ-ийн Дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл

Ердийн гишүүд



Бруно Рашле
Дэд Дарга,
Шродер Капитал Холдинг



Авирын **Сүхдорж**
Үүсгэн байгуулагч,
ГрэйпСити Монгол



Одончимэдийн **Одбаяр**
Гүйцэтгэх Захирал,
Мон-Интернэшнл

Хараат бус гишүүд



Арно Вентура
Үүсгэн байгуулагч,
Баобоб Групп



Мөнх-Очирын **Сэргэлэн**
Захирал,
ТТДС



Михиал Зелдович
Хяналтын зөвлөлийн дарга,
Кокуун капитал



Чулууны **Мөнхбат**
Ерөнхийлөгч,
Саусгоби сэндс



Роланд Нэш
Үүсгэн байгуулагч түнш,
VPE Капитал

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Холдинг компани



Б.Золбоо
Гүйцэтгэх захирал



Х.Билгүүн
Санхүү Эрхэлсэн
Захирал



Ж.Дашням
Дижитал Стратеги
Эрхэлсэн Захирал



Э.Төртогтох
Эрсдэл Эрхэлсэн
Захирал



Г.Сэлэнгэ
Ерөнхий
Нягтлан Бодогч



Б.Уянга
Хүний Нөөц Хариуцсан
Захирал



М.Мөнх-Эрдэнэ
Дотоод Аудитор



Ө.Ашхүү
Хуулийн Ахлах Зөвлөх

Охин компани



Г.Тэлмэн
Ард Кредит



Г.Билгүүн
Ард Актив



Г.Сүхбаатар
Ард Лизинг



Г.Цогбадрах
Ард Даатгал



О.Амарболд
Ардын Тэтгэврийн Данс



Ц.Бархас
Ард Секюритиз



Ч.Хандаа
Ард Менежмент



Г.Уянга
Ард Пропертиз



Ц.Солонго
Ард Суппорт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

БАНКНЫ КЛАСТЕР



Ард Кредит нь III улиралд Санхүүгийн Зохицуулах Хорооноос (СЗХ) 8.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл, Монголбанкнаас аутсорсингийн үйлчилгээ авах тусгай зөвшөөрөл тус тус авсан. Ингэснээр ийм төрлийн зөвшөөрөл авсан гурав дахь байгууллага болсон.

Тайлант хугацаанд Ард Кредитын зээлийн багц нэмэгдэж 50 тэрбум төгрөгийг давсан. Тодруулбал, он гарснаас хойш бидний баримталж буй биет болон цахим шийдлийг хослуулсан PHYGITAL аргачлалд суурилан автомашины зээлийн багцаа нэмэгдүүлэхээр зорьсны үр дүнд манай барьцаат зээлийн багц хоёр дахин нэмэгдэж, 8.4 тэрбум төгрөгт хүрээд байна.

Энэ өсөлтийн гол шалтгаан нь он гарснаас хойш Ард Кредит 35.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн шинэ эх үүсвэр татаж, 10.0 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлж чадсан явдал юм. Үүний хүчинд тус компани 1.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд хувьцаа нь (MSE: ADB) 110.81 төгрөгийн ханштайгаар улирлаа хааж, зах зээлийн үнэлгээ нь 31 тэрбум төгрөгт хүрлээ.

Түүнчлэн, Ард Кредит, Ардын Тэтгэврийн Данс компанитай хамтран "Ирээдүйдээ хөрөнгө оруул" аяныг амжилттай зохион байгуулсан. Энэхүү аян нь Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээг БНСУ дахь Монголчууддаа таниулах зорилготой байсан бөгөөд нийт 300 гаруй харилцагчид сургалтад хамрагдсан.



Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо гишүүдийн тоогоо нэмэгдүүлж 3,600 хүрсэн бөгөөд нийт хөрөнгө, зээлийн багц, хадгаламжийн багцаа тогтмол нэмэгдүүлж ажиллаж байна.





2023 оны III улиралд нийт хөрөнгө 39.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгөөрөө салбартаа тэргүүлэх хоёрдогч том хадгаламж, зээлийн хоршоо боллоо.

Тайлант хугацаанд Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо 14.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шинээр татаж, 13.1 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлж, нийт 27.8 тэрбум төгрөгийн хадгаламж татан төвлөрүүллээ. Цэвэр зээлийн багц 31.5 тэрбум төгрөг хүрч, 438.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Зээлийн багцийн 0.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 0.7 хувийг чанаргүй зээлийн багц эзэлж байна.







Ард Лизинг нь 2021 онд Өсдөг Машин хөтөлбөрийг нэвтрүүлж байсан бөгөөд тус хөтөлбөрийн 2 жилийн ойн хүрээнд харилцагчиддаа 2 жилийн хөрөнгө оруулалтын өгөөж олгож, 3 сая АрдКойныг хуваарилсан. Энэхүү санаачилга нь хөтөлбөрийг амжилттай үргэлжлүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьд харилцагчдынхаа итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байсан юм. Нэгдэл нь IV улиралд санхүүгийн болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор Ард Лизинг компанийг дахин хөрөнгөжүүлэхээр ажиллаж байна.

(Сая төгрөг)	Гол үзүүлэлт	2022 УЗ	2022	2023 УЗ	Жилийн өсөлт	Оны эхнээс
	Нийт хөрөнгө	74,512.3	58,038.7	69,079.3	(7.3%)	19.0%
	Нийт эздийн өмч	19,661.7	18,049.4	18,753.7	(4.6%)	3.9%
	Зээлийн багц (цэвэр)	35,014	40,038.1	50,057.3	43.0%	25.0%
	Санхүүжилт	38,136	32,466.1	41,137.6	7.9%	26.7%
	Чанаргүй зээл	12.8%	7.8%	6.9%	(46.1%)	(11.5%)
	Хугацаа хэтэрсэн зээл	20.0%	13.2%	11.9%	(40.5%)	(9.8%)
	Цэвэр ашиг	756.1	2,059.2	1,538.1		(25.3%)
Зээлийн багцын задаргаа: 2023 УЗ						



	Нийт хөрөнгө	31,123.2	31,487.7	39,601.9	27.2%	25.8%
	Нийт эздийн өмч	7,803.7	8,107.7	8,557.9	9.7%	5.6%
	Зээлийн багц (цэвэр)	23,180.3	25,441.9	31,462.6	35.7%	23.7%
	Санхүүжилт	21,861.4	21,866.9	29,202.3	33.6%	33.5%
	Чанаргүй зээл	0.94%	0.38%	0.70%	(25.5%)	84.2%
	Хугацаа хэтэрсэн зээл	1.35%	0.63%	0.96%	(28.9%)	52.4%
	Цэвэр ашиг	373.2	711.7	438.6	17.5%	(38.4%)
Зээлийн багцын задаргаа: 2023 УЗ						



	Нийт хөрөнгө	40,867.2	32,518.2	29,737.2	(27.2%)	(8.6%)
	Нийт эздийн өмч	2,257.4	(9,384.6)	(16,590.9)	(835.0%)	76.8%
	Зээлийн багц (цэвэр)	1,878.5	1,705.9	1,174.1	(37.5%)	(31.2%)
	Санхүүжилт	35,291.7	35,291.4	43,817.0	24.2%	24.2%
	Цэвэр ашиг	(1,977.3)	(3,398.8)	(5,238.9)	165.0%	54.1%

ДААТГАЛЫН КЛАСТЕР



Нийт хураамжийн орлого 22.8 тэрбум төгрөгт хүрч, 6,250 гаруй нөхөн төлбөрийн нэхэмжлэлд 8 тэрбум төгрөг төлөөд байна. Нийт хөрөнгө 43.1 тэрбум төгрөгт хүрч, хөрөнгө оруулалтын багц, биет бус хөрөнгө, нөөцийн сангийн хэмжээ өсөлт үзүүллээ. Эдгээр зэрэг үзүүлэлтийн хүчинд Ард Даатгал 1.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд хувьцаа нь (MSE: AIC) III улирлыг 797.93 төгрөгөөр хааж, зах зээлийн үнэлээ нь, 20 тэрбум төгрөгийг даваад байна.

Ард Даатгал нь хөрөнгө оруулалтын багцаа 26.8 тэрбум төгрөгт хүргэсэн бөгөөд цаашдаа тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтыг багцдаа нэмж, хөрөнгө оруулалтуудаа төрөлжүүлэхээр ажиллаж байна.

Мөн тус компани нь Ард Аппаар дамжуулан Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалыг анх удаа цахимаар санал болгодог болсон ба энэ нь даатгалын салбарт анхдагч бүтээгдэхүүн болоод байгаа юм.



Ардын Тэтгэврийн Данс компани нь нийт 34.3 тэрбум төгрөгийн хуримтлалыг бүрдүүлээд байна. Тэтгэврийн хуримтлалын урсгал 6.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 30.4 хувиар өслөө. Түүнчлэн, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын борлуулалт руу чиглэсэн ажлуудаа улам эрчимжүүлсэн. 2023 оны 9 сарын 30-ны байдлаар тэтгэврийн хуримтлал эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 34 хувиар өсөж 140,650 болсон ба хамтрагч байгууллагын тоо 97 хүрлээ.

Тус компани нь Монголын Стандарт Хэмжил Зүйн Газраас ISO 9001:2015 стандартын гэрчилгээг амжилттай авсан нь тэтгэврийн бүтээгдэхүүний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн төлөө тууштай ажиллаж байгааг тодотгож байгаа юм.


Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг 2023 оны 10 дугаар сарын 2-ны өдөр эхэлсэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөөд байгаа бөгөөд энэхүү хууль нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэх юм. Ардын Тэтгэврийн Данс компани нь 2023 оны 5 сард Америкийн Худалдааны Танхим болон Улаанбаатар Хотын Худалдааны Танхимаар дамжуулан Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөлд саналаа танилцуулсан.

(сая төгрөг)	Гол үзүүлэлт	2022 УЗ	2022	2023 УЗ	Жилийн өсөлт	Оны эхнээс
ARD ДААТГАЛ SINCE 1994	Нийт хөрөнгө	35,313	35,645	43,134	22.1%	21.0%
	Нийт эздийн өмч	18,009	16,679	16,908	(6.1%)	1.4%
	Хөрөнгө оруулалтын багц	25,603	24,394	23,540	(8.1%)	(3.5%)
	Нийт хураамжийн орлого	15,695	22,316	22,792	45.2%	2.1%
	Нийт нөхөн олговор	5,810	7,859	8,289	42.7%	5.5%
	Цэвэр ашиг	1,748	737	1,260	(27.9%)	71.0%

ARD ТЭТГЭВРИЙН ДАНС	Нийт хөрөнгө	44,608	36,541	34,841	(21.9%)	(4.7%)
	Нийт эздийн өмч	12,375	5,973	(3,603)	(129.1%)	(160.3%)
	Хөрөнгө оруулалтын багц	37,552	34,741	31,785	(15.4%)	(8.5%)
	Тэтгэврийн хариуцлага	24,807	26,716	34,333	38.4%	28.5%
	Тэтгэврийн хуримтлалын орлого	4,827	6,477	6,294	30.4%	(2.8%)
	Цэвэр ашиг (алдагдал)	(3,405)	(12,088)	(4,259)	(25.1%)	64.8%
	Нийт дэлгэрэнгүй орлого	(23,379)	(29,306)	(9,627)	58.8%	67.2%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ


ARD | ДААТГАЛ
SINCE 1994



Нийт хөрөнгө оруулалтын багц - 26,779 (Сая төгрөг)

- Тогтмол орлого - 15,967
- Бүртгэгдсэн хөрөнгө оруулалт - 6,624
- Альтернатив хөрөнгө оруулалт - 2,668
- Бусад хөрөнгө оруулалт - 1,520

ARD | ТЭТГЭВРИЙН
ДАНС



Нийт хөрөнгө оруулалтын багц - 31,785 (Сая төгрөг)

- Бүртгэгдсэн хөрөнгө оруулалт - 15,000
- Альтернатив хөрөнгө оруулалт - 8,277
- Хувийн өмч - 4,976
- Тогтмол орлого - 2,009
- Үл хөдлөх - 1,523

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР



Ард Секюритиз III улиралд Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 33.5 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг зуучилж, брокерын үйлчилгээний чиглэлээр өндөр гүйцэтгэлтэй ажилласан хэвээр байна. Мөн андеррайтер, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр туршлагаа өргөжүүлэн 35.0 тэрбум төгрөгийн санхүүжилт босгоход амжилттай оролцлоо.

Манай Ухаалаг Хөрөнгө Оруулагч – үнэт цаасны хуримтлалын бүтээгдэхүүн нь харилцагчдад хуримтлалын дадал суулгаж, урт хугацаанд үр өгөөж хүртэхэд тусалдаг бөгөөд одоогоор нийт 1,600 гаруй харилцагч 200 сая төгрөгийн багц бүрдүүлээд байна.

Мөн Ард Секюритиз МХБ-ийн түүхий эдийн арилжаанд брокероор оролцох стратегийн шийдвэр гаргаж, шаардлагатай бэлтгэл ажлаа хангаад байна.



Ард Менежмент нь III улирлын байдлаар нийлбэр дүнгээр 8 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэй хоёр хөрөнгө оруулалтын санг удирдан ажиллаж байна. 2022 оноос хойш Монголын хөрөнгийн зах зээл уналтад орсон ч дотоодын зах зээл урт хугацаандаа өгөөжтэй байна гэж бид харж байна. Тиймээс ч хоёр сан нь голчлон дотоодын хувьцаа, бондоос бүрдсэн багцыг бүрдүүлээд байгаа юм.

Ард Менежмент нь 2022 оны 10 сард Монголын анхны нээлттэй сан болох Хөрөнгө Оруулагч Үндэстэн Санг (ХОҮС) танилцуулж байсан бөгөөд тус сан нь GARP хөрөнгө оруулалтын стратегийг баримталж, нийт хөрөнгийн 58 хувийг хувьцаанд байршуулсан. Тус сан нь 15 компанийн хувьцааг эзэмшиж хөрөнгө оруулалтын хамгийн өндөр хувийг буюу 12.4 хувийг санхүүгийн үйлчилгээний салбарт төвлөрүүлээд байгаа юм. Одоогийн байдлаар ХОҮС нь 1,047 нэгж эрх эзэмшигчтэй.

Манай хаалттай сан болох Үндэсний Хувьчлалын Сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэн он гарснаас хойш 18 хувиар унасан ч бид сан байгуулагдсанаас хойш 15 хувийн өсөлтөө амжилттай хадгалсаар байна. Тус сан нь дотоодын 24, гадаадын 5 хувьцаанаас бүрдсэн 29 хувьцааны багцыг эзэмшдэг. Салбараар нь ангилбал санхүүгийн үйлчилгээний салбар хөрөнгө оруулалтын хамгийн өндөр жинг эзэлдэг. Тус сангийн Монголын Хөрөнгийн Бирж дэх арилжааны хэмжээ 297 сая төгрөгт хүрсэн бол хувьцаа эзэмшигчдийн тоо 6,305 байна. Цэвэр хөрөнгийн үнэ цэн буурсан ч ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ХОС нэгж эрх эзэмшигчдэдээ нэгж эрх тутамд 2.3 төгрөгийн ногдол ашиг хуваарилан тараасан.

Өдөр тутмын үйл ажиллагааны хувьд хөрөнгө оруулагчдыг цаг үеийн мэдээллээр хангах үүднээс цахим хуудсандаа иж бүрэн шинэчлэл хийж эхэлсэн. Мөн бид Компанийн засаглалын кодекс болон бусад шаардлагыг дагаж мөрдөн ажилласаар байна.




Ард Пропертиз компани Блю Скай цогцолборын 9, 11 давхарт нийт 2660.45 м.кв талбайг чанарын өндөр түвшинд шинэчлэн сайжруулж, ашиглалтад оруулаад байгаа бөгөөд эдгээр талбайг урт хугацаагаар түрээслүүлэх гэрээг гуравдагч этгээдүүдтэй амжилттай байгуулаад байна.

Түүнчлэн, Хөх Тэнгэр төслийн хүрээнд Ард Пропертиз компани Айдакс биржтэй хамтран сүүлийн гурван сарын түрээсийн орлогыг амжилттай хуваарилсан. Маркетинг идэвхжүүлэлтийн кампанит ажил явуулж эхэлснээр BS9 токены өдөр тутмын арилжааны эргэлт тогтвортой өсөлтийг үзүүлж эхэллээ.


Ард Пропертиз нь 2023 оны 7 сарын 5-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын хууль ёсны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан.

(сая төгрөг)	Гол үзүүлэлт	2022 УЗ	2022	2022 УЗ	Жилийн өсөлт	Оны эхнээс
 СЕКЮРИТИЗ ҮЦК	Нийт хөрөнгө	14,378	8,997	8,546	(40.6%)	(5.0%)
	Эздийн өмч	9,294	6,104	5,097	(45.2%)	(16.5%)
	Нийт орлого	1,744	2,605	1,811	3.8%	(30.5%)
	Цэвэр ашиг	-575	-644	-148	(74.3%)	(77.0%)
	Арилжаа	47,196	65,889	33,500	(29.0%)	(49.2%)
	Санхүүжилт	25,286	46,429	34,964	38.3%	(24.7%)
 МЕНЕЖМЕНТ КОМПАНИ	Нийт хөрөнгө	7,391	2,513	2,864	(61.3%)	14.0%
	Эздийн өмч	6,350	2,030	2,377	(62.6%)	17.1%
	Нийт орлого	518	533	512	(1.2%)	(3.9%)
	Цэвэр ашиг	(69)	(175)	(235)	240.6%	34.3%
	Удирдлагад буй хөрөнгө	5,963	9,550	8,006	34.3%	(16.2%)
 ПРОПЕРТИЗ КОМПАНИ	Нийт хөрөнгө	22,208	10,127	18,950	(14.7%)	87.1%
	Эздийн өмч	13,593	4,718	3,032	(77.7%)	(35.7%)
	Нийт орлого	410	510	233	(43.2%)	(54.3%)
	Цэвэр ашиг	(287)	(21)	(1,701)	492.7%	8,000.0%

Багцын задаргаа




Хөрөнгө оруулалт - Салбараар




ХОҮ - ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН САН

Багцын задаргаа




Хөрөнгө оруулалт - Салбараар



НЭГТГЭСЭН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

	2020	2021	2022	2023 УЗ	ОНЫ ЭХНЭЭС
Нийт компани	31	38	44	44	0
Нийт ажиллагсад	223	335	276	256	(20)
Хувьцаа эзэмшигч	12,296	62,418	59,109	100,059	40,950
Ард Апп хэрэглэгч	637,000	990,071	1,055,828	1,128,642	72,814
АрдКидс апп хэрэглэгч	-	22,113	36,921	50,590	13,669
АрдКойн эзэмшигч	286,117	516,425	543,538	418,618	(124,920)
Зээлийн данс (идэвхтэй)	19,942	23,385	15,700	20,750	5,050
Даатгуулагч (идэвхтэй)	74,947	86,089	105,816	160,451	54,635
Тэтгэврийн хуримтлал эзэмшигч	10,447	100,600	151,685	146,769	(4,916)
Үнэт цаасны данс эзэмшигч	89,305	146,893	151,651	154,496	2,845
Ард Актив ХЗХ-ны гишүүн	1,062	2,678	2,819	3,612	793
Тусгай зөвшөөрөл	37	43	44	45	1



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

Ардын охин **компаниуд** – Банк, Даатгал, Хөрөнгө оруулалтын банкны кластерын **компаниуд** хөрөнгө оруулалтын сангаас хамаарал бүхий **компаниуд** – бусад **компаниуд**, хөрөнгө оруулалтын сангууд болон И Ай Ти.

Банк


36% **

Даатгал

21% **


ББСБ

ARD КРЕДИТ
ББСБ




ХЗХ

ARD АКТИВ
ХЗХ



Ердийн даатгал

ARD | ДААТГАЛ
SINCE 1994



Тэтгэврийн сан

ARD ТЭТГЭВРИЙН
ДАНС



Лизинг

ARD ЛИЗИНГ
КОМПАНИ



Амьдралын даатгал

ARD ЛАЙФ
КОМПАНИ

Хөрөнгө оруулалтын банк 11% **

Бусад


12% **

Венчурс

20% **

ҮЦК

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК




Үл хөдлөх


ARD ПРОПЕРТИЗ
КОМПАНИ



Шуудан




Блокчэйн




ХОМК


ARD МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ



Медиа нэгдэл




Програм хангамж




Хаалттай сан

ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН




Нээлттэй сан

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН САН




Үнэт цаасны бирж

UBX Ulaanbaatar
Securities Exchange



Төлбөрийн платформ



* Нэгтгэсэн хөрөнгөд эзлэх хувь

** Нэгдсэн хөрөнгө

Ард Санхүү Нэгдлийн эзэмшил
 Холбоотой этгээдийн мэдээлэл
 МХБ дээр нээлттэй компани

АРД АПП


Ард Аппын томоохон хөгжүүлэлт болох 5.0 хувилбарыг эцэслэн боловсруулж, нэвтрүүлж, хэрэглэгчдийг 4.0 хувилбараас шилжүүлэх ажлыг амжилттай хийж дуусгалаа. Шинэчлэгдсэн аппликейшны талаар хэрэглэгчийн хүсэлт, сайжруулах санааг цуглуулах зорилгоор Ардын ажиллагсад дунд “Алдаа илрүүлэх” дотоод тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээний үр дүнд 40 гаруй сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Ажайл аргачлалд суурилсан программ хангамж хөгжүүлэлтийн стандартыг ашиглан Аппыг сайжруулах зорилгоор ГрэйпСити Монгол, МОСТ Финтек компаниудтай хамтарсан ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг энэ оныг дуустал хоёр долоо хоногт нэг удаа аппликейшны шинэчлэлтийг гаргахаар ажиллах юм.

Ард Аппын төслийн баг “Mini Game on Ard App” хактоныг амжилттай зохион байгуулсан ба уралдааны хүрээнд 10 баг Ард Апп дээр гар утасны тоглоом хөгжүүлэхээр ажилласан. Эдгээр тоглоомууд 10 сараас эхлэн Ард Апп дээр нэвтэрч эхлэх бөгөөд эдгээрээр дамжуулан Ард Апп болон АрдКойны хэрэглээг нэмэгдүүлэхийг зорьж байна.

“Сурсак бүтээгдэхүүн дээр илүү их ач холбогдол өгснөөр шинэ дансны тоо 40 хувиар нэмэгдсэн

Монголбанкны шаардлагын дагуу Fast Cash зээлийн бүтээгдэхүүнийг Урт болон Богино хугацаат хэрэглээний зээл болгон шинэчилсэн.”



Шинэчлэгдсэн нүүр хуудас

2023 УЗ Үзүүлэлт / 2022 УЗ харьцуулалт /

Ард Апп нийт хэрэглэгчид

1,128,642 ▲ 8.3%

Гүйлгээний тоо

1,027,625 ▲ 6.8%

Олгосон цахим зээл (тэрбум төгрөг)

78.6 ▲ 50.9%

Нийт шилжүүлэг (тэрбум төгрөг)

288.3 ▲ 0.3%

АрдКидс хэрэглэгчид

50,590 ▲ 61.3%

Татсан хадгаламж (тэрбум төгрөг)

14.2 ▲ 108.8%

Үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөг)

9.6 ▼ 23.2%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ - AARD

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ	2023.06.30	%	2023.09.30	%	Улирлын өөрчлөлт	Өөрчлөлт-ийн хувь
И Ай Ти ХХК	3,128,670	10.93%	3,039,503	10.62%	(89,167)	(0.31%)
Ардын Тэтгэврийн Данс ХХК	1,764,353	6.17%	2,467,285	8.62%	702,932	2.46%
Бруно Рашле	2,109,997	7.37%	2,109,997	7.37%	0	0.00%
А.Сүхдорж	1,944,990	6.80%	1,944,990	6.80%	0	0.00%
Ч.Ганхуяг	1,576,442	5.51%	1,579,994	5.52%	3,552	0.01%
Ард Венчурс ХХК	1,498,647	5.24%	1,498,613	5.24%	(34)	(0.00%)
Голомт Кастодиан Банк	1,526,910	5.34%	900,000	3.15%	(626,910)	(2.19%)
Айдакс (ARDT)	900,000	3.15%	900,000	3.15%	0	0.00%
Ардын Тэтгэврийн Данс	626,910	2.19%	0	0.00%	(626,910)	(2.19%)
Г.Уянга	1,389,754	4.86%	1,389,754	4.86%	0	0.00%
Ард Лизинг ХХК	631,621	2.21%	632,171	2.21%	550	0.00%
С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.59%	0	0.00%
Ронок Лимитед	443,816	1.55%	443,816	1.55%	0	0.00%
Ард Секюритиз УЦК	408,209	1.43%	401,640	1.40%	(6,569)	(0.02%)
С.Оргил	390,937	1.37%	390,937	1.37%	0	0.00%
Г.Бат-Эрдэнэ	351,268	1.23%	351,268	1.23%	0	0.00%
Н.Мөнхнасан	344,311	1.20%	344,311	1.20%	0	0.00%
Масик Энтерпрайзес	321,078	1.12%	321,078	1.12%	0	0.00%
Х.Батхишиг	319,381	1.12%	319,346	1.12%	(35)	(0.00%)
Ард Даатгал ХК	253,265	0.89%	253,265	0.89%	0	0.00%
Ард Кредит ХК	249,019	0.87%	251,217	0.88%	2,198	0.01%
Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.82%	0	0.00%
Топ 20	19,341,906	67.60%	19,328,423	67.55%	(13,483)	(0.05%)
Бусад	9,272,357	32.40%	9,285,840	32.45%	13,483	0.05%
Эргэлтэд буй хувьцаа	28,614,263	100%	28,614,263	100%	-	0
Халаасны хувьцаа						
Нийт гаргасан хувьцаа	28,614,263				-	-
Хувьцаа эзэмшигчид	19,301		18,822		(479)	
ARDT эзэмшигчид	3,064		3,064		0	
ARDT эзэмшигчид (Хүүхэд)	48,056		49,367		1,311	

ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

орлогын тайлан

(сая төгрөг)	2022 УЗ	2022	2023 УЗ
Менежментийн орлого	2,180	2,837	1,415
Хөрөнгө оруулалтын орлого	3,504	3,657	0
Ногдол ашгийн орлого	1,012	1,012	0
Хүүгийн орлого	599	18	1,013
Нийт хөрөнгө оруулалтын орлого	7,295	7,525	2,428
Бусад орлого	6,331	6,250	2,621
Нийт орлого	13,626	13,776	5,049
Борлуулалт, маркетингийн зардал	2,092	2,228	1,738
Үйл ажиллагааны зардал	7,014	7,125	5,310
Санхүүгийн зардал	3,005	3,160	2,302
Бусад зардал	82	175	300
Нийт зардал	12,192	12,688	9,650
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(32)	(31)	11
Бусад олз (гарз)	0	1,234	
Татварын өмнөх ашиг (алдагдал)	1,402	2,291	(4,590)
Орлогын албан татварын зардал	(870)	180	38
Цэвэр ашиг	2,272	2,111	(4,628)
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз (гарз)	(56,014)	(155,722)	(20,824)
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	(53,742)	(153,611)	(25,452)
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг)	79	74	(162)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(сая төгрөг)	2022 УЗ	2022	2023 УЗ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	38	4	1
Дансны болон бусад авлага	22,004	21,638	35,755
Бусад санхүүгийн хөрөнгө	20	366	694
Бараа материал	121	98	104
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,355	4,644	6,893
Нийт эргэлтийн хөрөнгө	26,538	26,749	43,446
Үндсэн хөрөнгө	469	419	504
Биет бус (Виртуал) хөрөнгө	49,295	12,020	11,280
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,471	1,282	742
Урт хугацаат хөрөнгө оруулалт	183,958	96,138	79,412
Нийт эргэлтийн бус хөрөнгө	235,193	109,859	91,938
НИЙТ ХӨРӨНГӨ	261,731	136,608	135,384
Дансны болон бусад өглөг	19,529	4,206	19,864
Богино хугацаат өр төлбөр	5,963	2,578	3,709
Богино хугацаат бондын өглөг	2,559	2,603	1,020
Богино хугацаат түрээсийн өглөг	560	866	234
Урьдчилж орсон орлого	1,610	9,966	11,587
Нийт богино хугацаат өр төлбөр	30,221	20,220	36,413
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	1,059	608	608
Урт хугацаат зээл	2,300	5,981	16,691
Хойшлогдсон татварын өр	17,942	6,187	3,873
Нийт урт хугацаат өр төлбөр	21,301	12,776	21,172
НИЙТ ӨР ТӨЛБӨР	51,522	32,996	57,585
Өмч-хувьцаат	28,614	28,614	28,614
Нэмж төлөгдсөн капитал	2,928	2,928	2,928
Дахин үнэлгээний нөөц	158,333	52,793	31,969
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14
Хуримтлагдсан ашиг	20,320	19,264	14,274
Эздийн өмч	210,209	103,612	77,799


ҮНЭЛГЭЭ

(сая төгрөг)	Суурь	2022 үз	%	2022	%	2023 үз	%	YTD	YoY
Стратегийн хөрөнгө оруулалт		118,330		91,698		83,261		(9%)	(30%)
Ард Даатгал (MSE: AIC)	MV	8,021	45%	10,535	45%	9,099	46%	(14%)	13%
Ард Кредит (MSE: ADB)	MV	10,657	41%	14,630	41%	12,705	41%	(13%)	19%
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	15,276	24%	16,008	20%	16,032	20%	0%	5%
Ард Секюритиз	BV	8,234	90%	5,644	90%	5,472	90%	(3%)	(34%)
Ард Менежмент	BV	1,777	90%	1,870	90%	3,188	90%	70%	79%
Ард Актив	BV	773	10%	804	10%	623	10%	(23%)	(19%)
Ардын Тэтгэврийн Данс	BV	9,510	95%	9,510	95%	10,010	100%	5%	5%
Ард Лизинг	BV	1	100%	1	100%	0	100%	(100%)	(100%)
ТэнГэр Системс	BV	1,076	100%	1,076	100%	1,956	100%	82%	82%
Ард Венчурс	BV	3,601	100%	0	0%	0	0%		
Ард Пропертиз	BV	3,724	100%	4,788	100%	3,032	100%	(37%)	(19%)
Ард Бит	BV	6,297	100%	0	0%	0	0%		(100%)
DAX	DCF	4,500	60%	0	0%	0	0%		(100%)
Даац Инвестмэнт	Cost	4,096	51%	4,096	51%	4,178	51%	2%	2%
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR)	MV	27,288	38%	22,737	38%	16,967	38%	(25%)	(38%)
ГрэйпСити Монгол	Cost	9,000	45%						(100%)
МОСТ Финтек	Cost	4,500	45%						(100%)
Тактикийн хөрөнгө оруулалт		6,735		1,069		2,376		122%	(65%)
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	MV	11	0%	26		42	1%	62%	282%
КриптоҮндэстэн	MV	1,733	28%	589		334	6%	(43%)	
Бусад санхүүгийн хэрэгслүүд		4,991		454		2,000		341%	(60%)
Бусад		22,727		40,015		2,622		(93%)	(88%)
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө		10,174		13,632		1,423		(90%)	(86%)
Бэлэн мөнгө		38		4		1		(75%)	(97%)
Бусад цэвэр хөрөнгө		12,516		26,379		1,197		(95%)	(90%)
Нийт үнэлгээ		147,792		132,781		88,258		(34%)	(40%)
Нэгж хувьцааны үнэлгээ		5,165		4,640		3,084		(34%)	(40%)


ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

— Close price ■ Volume


MSE: AARD trading chart




MSE: AIC trading chart



MSE: ADB trading chart



MSE: MNP trading chart



Тикер	2023 Q3 (улирлын)		52 долоо хоног		2023 Q3 (улирлын)		52 долоо хоног		2023/09/30	
	Дээд	Доод	Дээд	Доод	Арилжааны дүн	Эргэц %	Арилжааны дүн	Эргэц %	Хаалтын ханш	33Ү
AARD	3,439.0	2,975.0	5,545.0	2,913.0	0.71B	0.79%	9.16B	8.55%	3,180	90.99B
AIC	831.0	749.0	997.0	681.1	0.13B	0.67%	1.77B	8.17%	797.93	19.95B
ADB	134.0	106.0	142.0	88.5	0.3B	0.87%	1.51B	4.83%	110.81	31.03B
MNP	920.0	750.0	1,031.0	590.0	0.02B	0.02%	4.12B	5.94%	715.37	71.24B
TNGR	12,000.0	7,505.0	17,000.0	7,505.0	0.08B	0.13%	0.71B	1.16%	7,505	45.03B
CNF	78,000.0	49,000.0	90,720.0	40,000.0	0.13B	2.03%	1.85B	29.83%	52,000	5.89B
XOC	103.9	92.3	128.0	92.3	0.08B	1.53%	0.47B	8.89%	99.36	4.97B



 www.ardholdings.com

 info@ardholdings.com

 +976 7700 3322